



ГАЛЗУУ·САХИЛГАГҮЙ·ХУЙВАЛДААНТАЙ

*Романтик*  
*В*

Галзуу, сахилгагүй, хуйвалдаантай 50 Романтик санаанууд  
Зохиолч: Т.Батсүрэн

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

# Замын цагдаа

Хэрвээ хайрт чинь машинтай бол Замын Цагдааг гуй. Цагдаа ах түүнийг чинь зогсоогоод “THANKS FOR BEING IN MY LIFE” гэсэн бичигтэй цаас өгөг. Цагдаа ахаас битгий ай, чиний ах шиг, найз шиг, аав шиг чинь л тусална, ийм тохиолдолд. Хамгийн гол нь Цагдаа ах бүх бичиг баримтыг нь шалгаж, яг л ажлаа хийж байгаа юм шиг л байх хэрэгтэй шүү. Шалгуулж дуусаад явахад нь нөгөө бичигтэй цаасаа өгүүлчих. Тэгээд л болоо. Цагдаа ахтай ингэж хуйвалдана гэж хэн санах юм бэ? Хи...хи...хи...

# Пицца

Пицца захиалахдаа пиц цагаа зүрхэн хэлбэрээр зүсүүл. Мах, ногоогоор нь ангилуулж, зүрхнийх нь гадна дотор талаар байрлуулан тавь. Бас бяслагаар нь пиццан дээрээ хайртынхаа нэрийг нь бичүүл.

# Нэрнийх нь үсэгнүүд

Ном худалдан авч өг. Эхний хуудсан дээр байгаа үгнүүдээс хайртынхаа нэр ний үсэгнүүдийг тодруулаг чаар тодруул.

# Дуртай дуу

Хайртынхаа дуртай дууг утасных нь дуудлага дээр тавихдаа зөвхөн чамаас дуудлага ирэхэд дуугарч байхаар сонго. Чамайг түүн рүү залгах бүрт хайрт чинь тэр дууг сонсох болно.

# ФМ

Фм-ээр хайртдаа ая дууны мэндчилгээ хүргүүл.

“..... фм-ээс ярьж байна. Танд ая дууны мэндчилгээ ТЭРНЭЭС (өөрийнхөө нэрийг хэлүүлнэ) дэвшүүлж байна” гээд сүлд дуугаа сонсго. Төд удалгүй хайртын чинь утас дахиад дуугарахад мөн л аль нэгэн фм-ээс...

# Дэлгүүр

Хайртыгаа ганцааранг нь дэлгүүр хэсүүл. Нэг найзыгаа явуулаад: “ТАНД ТУСЛАХАД ХЭЗЭЭД БЭЛЭН / Утасныхаа дугаарыг бич/” гэсэн цаас өгүүл.



# Дурсгалын карт

Ганцаараа явж байхад нь хэн нэгэн хуйвалдсан хүнээ явуулаад “ЧИ МИНЬ ХАМГИЙН ХӨӨРХӨН НЬ ШҮҮ. ТЭРНЭЭС (өөрийнхөө нэрийг бичнэ)” гэсэн бичигтэй дурсгалын картаа өгүүл.

# SMS

Олон найзуудтайгаа хуйвал дана. Хайртдаа: “ТЭР (Өөрийн хөө нэрийг бич) ГАНЦХАН ЧАМД ХАЙРТАЙ” гэсэн смс явуул. Гэхдээ бүгдийг нь нэг өдөр, 10,10 минутын зайтай. Фейсбүүкийн найзуудаасаа тусламж хүс.

# Бааранд

Түжигнэсэн диско ая гэнэт зогсож та хоёрын сүлд дуу явна. Тэр аян дээр зөвхөн та хоёр л бүжиглэхээр Баарны зохион байгуулагч, ДЖ болон хамгаалагч нартай хуйвалд. Та хоёрын сүлд дуун дээр хэн нэг нь хайрын шүлгийг микрофоноор заал дүүрэн гэхдээ намуухнаар уншиж өгөг. Шүлгэн дундуур хайртынхаа нэрийг оруулж уншуулаарай. Тэгээд, хайртыгаа тэврээд үнс. Яг л кинон дээр гардаг шиг. Харин шүлэг дууссаны дараа бааранд байгаа бүх хүмүүс алга нижигнүүлэн таших ёстой гэдгийг битгий мартаарай.

# Хайртынхаа цонхны дор

Найрал хөгжим урьж авчран, хайртыгаа цонхоор хартал нь ямар нэгэн сайхан дуу тоглуул. Хайрт чинь цонхоор харахгүй бол, хүн явуулж, хаалгыг тогшуулаад, бяцхан цаас өгөг. Түүн дээр “Цонхны чинь дор байна” гэж бичсэн байна.

# Хошин шогийн тоглолт

Хошин шогийн жүжигчинтэй хуйвалд. Тоглолт дундуур жүжигчин хайртыг чинь тайзан дээр урьж гаргаад нийт үзэгчдэд хандан жүжигчний хэлснийг дуурайн хэлэхийг уриална. Жүжигчин хайртын чинь гарнаас барин нүд рүү нь харж байгаад “ЧИ ИХ ҮЗЭСГЭЛЭНТЭЙ ЮМАА” гэж хэлнэ. Үзэгчид дуурайн хэлнэ. “ТЭР (чиний нэрийг хэлнэ) ЧАМД ХАЙРТАЙ” гэж жүжигчин хэлнэ. Үзэгчид дуурайн хэлнэ. Тоглолт үзэн суугаа бүх үзэгчид бүгдээрээ нэгэн зэрэг хэлэхээр хайрт чинь догдолж л таараа.

# Плакат

Хайртын хаа гоё гарсан зургийг аваад маш том хэмжээгээр угаалга. Хам гийн гол нь зурагны пиксел нь маш сайн байх хэрэгтэй. Тэгээд өөрт нь бэлэглэ. Зургаа угаалгахаасаа өмнө хайрт чинь өөрийнхөө зургийг хананд дээрээ наах нь уу, эсвэл өлгөх нь үү гэдгийг нь урьдчилан мэдээд ямар материал дээр хэвлүүлэхээ сонгоорой.

# Онъсого таалцах

Хайрттайгаа онъсого зохиож таал цаарай.

Цагаан юман дотор хар хөөрхөн юм, тэр юу вэ?

Хариулт нь:

“Чиний минь нүд” байх юм шүү.

-Хөөрхөн юм, тэр юу вэ?

-Тийм онъсого байхгүй...

-Чиний уруул гэх мэт.

# Тогтмол бэлэг

Хайртдаа долоо хоногт нэг удаа тогтсон өдөр, тогтсон цаг минутанд ямар нэгэн бэлэг илгээ. Хамгийн гол нь чиний илгээх бэлгийг хүлээдэг болтол нь уйгагүй байх хэрэгтэй. Жишээ нь Даваа гариг бүрийн 11 цагт гэх мэтээр.



# Хоол

Өөрийнхөө хоолныхоо хамгийн амттайг нь хайртынхаа тавган дээр тавина мөн хайртынхаа хоолноос ч жишим ч үгүй халбагадан ид.

# Таалагддаг зүйлээ бичих

Бие биенийхээ таалагддаг зүйлүүдийн тоочих санал тавь. Чинийх их байх тусмаа сайн.

# Календарь

Хайртдаа календарь бэлэг лэнэ. Түүн дээр өөрийн боловсруулсан хамт байх өдрүүдийн төлөвлөгөөг тэмдэглэсэн байна. Жишээ нь:

- 06 сарын 19-нд: Чамд массаж хийж өгнө.

- 06 сарын 20-нд: Хоёулаа хошин шогийн тоглолт үзнэ.

# ТОГТМОЛ ТӨЛӨВЛӨГӨӨ

Долоо хоног бүрийг төлөвлө. Жишээ нь:

- Даваа гариг бүр: Киноны өдөр. Хоёулаа танай гэрт кино үзнэ.
- Мягмар гаригт: Миний хоол хийх ээлж.
- Лхагва гаригт: Чиний хоол хийх ээлж.
- Пүрэв гаригт: Бие биенийхээ хумсыг авч өгнө гэх мэтээр.

# Дурлалын захиа

Хайртдаа зориулан захиа бич. Үргэлжлүүлэхийг түүнээсээ хүс. Хамт байх боломжгүй бол чатаар эсвэл майлаар харилцсан ч болно. Эсвэл утсаараа.

# Хун шувуу

Хамтдаа цаасан хун шувуу хийгээд гол дээр тавина. Хун яаж хийх зааврыг эндээс аваарай.  
<https://www.youtube.com/watch?v=f0zTNCRg-Uc>

# Өглөөний нар

Нар мандахаас өмнө хайртыгаа аваад ойрхон байгаа толгод эсвэл өндөрлөг газар луу гар. Тэндээс нар мандахыг хар. Гараа алдлаад наранд хүслээ шивнэ гээрэй. Хүсэл биелдэг юм.

# Төгөлдөр хуурч

Амьд хөгжим тоглодог зоогийн газар ор. Хөгжим чинтэй урьдчилан ярилцсан байх хэрэгтэй. Боломжтой үеийг тохи руулан төгөл дөр хуурчид дохио өгч хайртынхаа дуртай хөгж мийг тоглуул. Тэр үед зөөгч ирж хайртад чинь чиний бэлдсэн бэлгийг өгнө.



# Шөнийн одод

Үүлгүй цэлмэг шөнө хайрттайгаа оддыг харан зогс.

# Унтлагын смс

Хамт байх боломжгүй үед смс-ээр “Зэрэг орондоо орж унтах” тухай санал тавь. Хайртыгаа унтсаных нь дараа “Үнсье, чамайгаа санаж байна шүү” зэрэг хайрын смс илгээ.

# Windows movie

Өөрсдийн амьдралд тохиолдсон онцлог үйл явдлуудын зургуудаа ашиглан зургийн түүвэр хий. Зурагнууд ээлжлэн солигдож байх үед ард нь өөрсдийнхөө дуртай дуу явж байх ёстой гэдгийг оруулаарай. Дээрх програм байхгүй эндээс татаж ав. <http://windows.microsoft.com/en-us/windows-live/movie-maker#t1=overview>

# Хос хувцас

Яг адилхан хувцасла.

# Зохиол бичих

Хайрттайгаа хамт

# “..... Хоёрын хайрын түүх”

гэсэн нэртэй зохиол бичээрэй. Та хоёр анх яаж танилцсан, хэзээ хаана уулзсан, тэр үед гадаа ямар байсан, ямар мэдрэмж төрж байсан гэх мэт бүх зүйлийг яг л зохиолч шиг бичээрэй. Майлаар харил цан үргэлжүүлж болно. Зохиолоо бичиж дуусгаад хэвлэж гаргахдаа хавтсан дээр нь өөрсдийнхөө зургаа тавина.

# Гурван жилийн тэмдэглэл

Номын дэлгүүрүүдээр “Гурван жилийн тэмдэглэл” гэсэн дэвгэр байдаг. Хэзээ танилцсан, танилцсанаас хойших жилийн дараа яг тэр өдөр юу хийж байсан мөн өнөөдөр, өчигдрийг хамтдаа хэрхэн өнгөрөөсөн, түрүү жилийн яг энэ өдөр та хоёр юу хийж байсан тухайгаа тэмдэглэж бай.

# Валентиний өдрөөр

Хайрттайгаа нэгэн газар уулзахаар болз. Чи өөрөө 10 ширхэг сарнай худалдан аваарай. Тэгээд 10 минут хоцорч очно гэдгээ гэнэт хэлээд холоос утсаараа эсвэл видео камераар бичлэг хий. Чамайг хүлээж байх хооронд чиний урьдчилан бэлдсэн хүмүүс түүнд нэг нэгээрээ цэцэг аваачиж өгнө. 10 минутын турш шүү, хайртдаа уйтгарлах боломж бүү өгөөрэй. Бичлэг хийхдээ хамгийн гол нь царайг нь сайн авах хэрэгтэй. Яаж догдолж байна, эсвэл гайхаж байна уу гэдэг нь бичлэгт үлдэх нь чухал. Цэцэг хүргэлтийн хоорондын хугацааг нэг минутаас хэтрүүлэхгүй байх хэрэгтэй.



# Гэрлэх санал

Хулдаасан хэвлэлээр “НАД ТАЙ ГЭРЛЭЭЧ” гэсэн үгийг томоор хэвлүүлж хайртынхаа байрны урд, харагдахуйцаар газар дэлгэн тавь.

# Танилцах

Хайрттайгаа болзоод, хоёулаа дахин танилцаж байгаа мэт бай. Болзсон газраа очингуутаа шууд уулзахгүй шүү. Хоёр өөр ширээг болон бие биенээ ямар нэгэн зүйлээр халх лахгүй байрлал сонгоорой. Тэгээд аль зоригтой нь түрүүлж очоод яриа өднө. “Танилцъя”, “Уучлаарай, цаг хэд болж байгаа бол?”, (за, энэ ч бараг хуучирсан даа), “Хүн хүлээж байгаа юм уу?” гэх зэргээр эхлүүлээрэй. Нэр, ажлын газар, хобби гээд л яг анх танилцаж байгаа хүмүүс шиг л байгаарай.

# Сүлд дуу

Өөрсдийнхөө нэрийг орол цуулсан сүлд дуу зохио. Дууны үгийг хамт бичиж, дууны аяг нь хамтдаа зохио. Үүнийг бүр ажил хэрэг болгон төлөвлө. Дууны ая их хөгжилтэй байх хэрэгтэй шүү.

# Дохио зангаа

Зөвхөн та хоёр л ойлгож байхаар дохио зангаа бодож ол. Дохио зангаа нь бусад хүнд тайлагдашгүй байх хэрэгтэй. Жишээ нь:

- Зүүн нүдээ ирмэвэл- Хоолонд оръё.
- Баруун гараараа үсээ илбэл-Гадагшаа гаръя.
- Зүүн гараараа үсээ илбэл-Гадагшаа гарахаа болих уу?

# Тоглоом

Хайрттайгаа “Зуун найм” гэдэг тоглоом тогло.

# Аялал ба мод

Түүний гэр бүлийнхэнтэй хамтран аялал зохион байгуулж, салхинд гар. Бас мод тарь.

# Дэлгүүрт

Shopping хийж байхдаа хайртыгаа нэрээр нь битгий дуудаарай. Олон хүмүүсийн дунд гэнэт “Хөөрхөн нүд ээ”, “Гоё бие ээ” эсвэл “Царайлаг аа” гэж дууд. “Хайр аа, ...” гэж дуудахыг моодноос гарга.

# Үсний даруулга

Найз охиндоо гялалзсан шигтгээтэй ТИГЭМ шиг хэлбэртэй үсний гоёлын даруулга бэлэглээрэй.. Үсний даруулгаа худалдаж аваад бэлэгний хайрцганд хий, түүнийгээ дахин нэг бэлэгний хайрцганд мөн дахин нэг бэлэгний хайрцганд хий. Тэгээд дээр нь “Миний Хатан Хаан .... (хайртынхаа нэрийг бичнэ)-д” гэж бичнэ. Шуудангаар илгээ. Хаяг, утасны дугаарыг нь тодорхой бичээрэй.



# Сормуус

Сормуусаа тоолж үзсэн үү? Хайртынхаа сормуусыг тоолоорой. Нүд рүү нь гараа хийчихэв дээ, зөөлөн болгоомжтой байгаарай. “Нэг, хоёр, гурав, дөрөв...” гээд аман дотроо аяархан хэл.

# Ярихгүйгээр ярилцах

Өөд өөдөөсөө харан сууж хоёр минут орчим ширтэлцэнэ. Дараа нь бие биедээ асуулт тавина. Нэг нь асуулт тавихад, нөгөө нь хариулна. Ярихгүй, дохио зангаа хэрэглэхгүй, зөвхөн харцаараа.

# Гүзээлзгэнэ

Хайртдаа ваартай таримал гүзээлзгэнэ бэлэглэ. Гүзээлз гэнийг цонхны дор, наранд байрлуулбал хурдан урга даг. Бас хэд хоноод л жимсээ өгч эхэлдэг юм.

# Онгоц буудах

Дөрвөлжин хээтэй дэвтэр ашиглан “Онгоц буудаж” тогло.

# Нүүр будагчин

Хайртдаа make-up хий. Эмэгтэй нь эрэгтэйгийнхээ сормуус, уруулыг нь будаж, крем тавь. Гэхдээ их гоё болгож будаарай. Хиймэл сормуус хийсэн ч болно. Дараа нь урт даашинз өмсүүлээд, гэдсэнд нь дэр эсвэл бөмбөг хийгээд жирэмсэн юм шиг болго. Мөн найз охиныгоо эрэгтэй төрхтэй болгож будна. Сахал зурж, эрэгтэй хувцас өмсүүлнэ. Урт үсийг харагдуулахгүй байя гэвэл малгай өмсүүлээрэй. Гутал хувцас багадсан эсвэл томдсон байх нь та хоёрыг илүү хөгжилтэй болгоно. Нүүр будалтын явц дунд зураг аваарай.

# Зэрэгцэн ярих

Хосууд ямар нэгэн юмны тухай нэгэн зэрэг ярьж эхэлнэ. Тохиолдсон үйл явдал, кино, дурсамж эсвэл бүр шүлэг уншиж болно. Хэсэг хугацаанд ярьсны дараа хайртынхаа юу ярьсныг ойлгосон эсэхийг шалгана.

# Гадаад хэл зохиох

Хайрт чинь чамаас ямар нэгэн асуулт асууг. Хариултыг нь өөрийнхөө зохиосон “гадаад хэл”-ээр өгнө. Бас өөрийнхөө зохиосон “гадаад хэл”-ээр хайртаасаа асуулт асуух зэргээр харилцан ярилц. Бусад хүмүүсийн хажууд өөрсдийн “Зохиосон хэл”-ээрээ ярь.

# Мөнгөний гахай

Дурсгалын эд зүйлс зардаг дэлгүүрээс мөнгөний гахай худалдаж авна. Энэ дотор цуглуулгын мөнгө хийхгүй ээ. Харин жижигхэн цаасан дээр бичсэн дурсамжуудаа цуглуулна. Жишээ нь: “Би чамайг ямар их санаж байна гээч. \_\_\_\_ он \_\_\_\_ сар \_\_\_\_ өдөр. Тэрнээс (Өөрийнхөө нэрийг бичнэ)” гэх мэт.



# Усанд орох

Хайрттайгаа хамт шүршүүрт эсвэл хөөстэй ваннд орж жаахан хүүхдүүд шиг тоглоомоор тогло. Хөвдөг усан онгоц, дэгдээхий гээд л төрөл бүрийн тоглоомнууд байдаг шүү дээ.

# “Photoshop”

Хайртыгаа хувцсаа тайлж байх үед хэрэглээд үзээрэй. Эхлээд бэлдэх хэрэгтэй. Толины урд зогс, нүдээ томруулаад, амаа ангай. Хэлэх үггүй болсон мэт царай гарга, толгойгоо сэгсэр. Тэгээд ингэж хэл. “Чиний бие яг фотошопдчихсон юм шиг гоё юмаа.”

# Үнэ бичдэг цаас

Номын дэлгүүрээс үнэ бичдэг цаас өнгө өнгөөс нь аваад дээр нь хайртынхаа нэрийг бич. Бас хайртай гэж бич. Хаа ч хамаагүй наа. Цонхны хөшиг, хөргөгчин дэх алим, ногоо, дэрний уут, хөнжил, дэвсгэр даавуу, шүдний сойз, 00-ын цаас, угаалтуур, уншиж байгаа номон дээр нь.

# Яриан дундуур нь

Хайртыгаа ямар нэгэн зүйл ярьж байхад нь уруул дээр нь долоовор хуруугаараа зөөлөн хүрээд “Чамд маш чухал юм хэлье. Би чамд хайртай ” гэж хэл. Тэгээд уруул дээр нь зөөлөн үнсээд яриагаа үргэлжлүүлэхийг санал болго. Түүний яриаг дуусахаас өмнө яриаг нь дахин тасал. Маш соёлтой, эелдгээр шүү. “Чамд маш чухал юм өгөх гэсэн юм” гэж хэлээд “Би чамд хайртай” гэж бичсэн цаасаа өг.

# Яриаг нь ойлгохгүй

Хайртыгаа ямар нэгэн юм ярьж эхлэхэд нь яг цэх өөдөөс нь харан тухлан суу. Түүний нүд, уруул, сормуус, хөмсөг гээд л бүгдийг сайн ажиглан хар. Тэгээд “Би чамайг харахаар би юу ч ойлгохгүй болчих юм ” гэж хэл.

# Table of Contents

[Замын цагдаа](#)  
[Пицца](#)  
[Нэрнийх нь үсэгнүүд](#)  
[Дуртай дуу](#)  
[ФМ](#)  
[Дэлгүүр](#)  
[Дурсгалын карт](#)  
[SMS](#)  
[Бааранд](#)  
[Хайртынхаа цонхны дор](#)  
[Хошин шогийн тоглолт](#)  
[Плакат](#)  
[Онъсого таалцах](#)  
[Тогтмол бэлэг](#)  
[Хоол](#)  
[Таалагддаг зүйлээ бичих](#)  
[Календарь](#)  
[Тогтмол төлөвлөгөө](#)  
[Дурлалын захиа](#)  
[Хун шувуу](#)  
[Өглөөний нар](#)  
[Төгөлдөр хуурч](#)  
[Шөнийн одод](#)  
[Унтлагын смс](#)  
[Windows movie](#)  
[Хос хувцас](#)  
[Зохиол бичих](#)  
[“..... Хоёрын хайрын түүх”](#)  
[Гурван жилийн тэмдэглэл](#)  
[Валентиний өдрөөр](#)  
[Гэрлэх санал](#)  
[Танилцах](#)  
[Сүлд дуу](#)  
[Дохио зангаа](#)  
[Тоглоом](#)  
[Аялал ба мод](#)  
[Дэлгүүрт](#)  
[Үсний даруулга](#)  
[Сормуус](#)  
[Ярихгүйгээр ярилцах](#)  
[Гүзээлзгэнэ](#)

[Онгоц буудах](#)

[Нүүр будагчин](#)

[Зэрэгцэн ярих](#)

[Гадаад хэл зохиох](#)

[Мөнгөний гахай](#)

[Усанд орох](#)

[“Photoshop”](#)

[Үнэ бичдэг цаас](#)

[Яриан дундуур нь](#)

[Яриаг нь ойлгохгүй](#)